



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/579

Булган сум

Г Хонины цэцэг өвчнөөс сэргийлэх яаралтай Г  
дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.5, 9.6, 9.7, 9.8 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын арга хэмжээг Могод, Гурванбулаг, Дашинчилэн, Баяннуур, Рашаант сумдын эрсдэл бүхий баг, нутаг дэвсгэрийн мал сүрэгт 2024 оны 08 дүгээр сарын 12-ны өдрөөс 08 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг зохион байгуулахад шаардагдах (тариур, зүү, шатахуун, бусад) зардлыг гаргаж, хүн хүч, техник хэрэгслээр хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хонины цэцэг өвчнөөс сэргийлэх яаралтай дархлаажуулалтын хуваарийг хавсралтаар баталж, шуурхай зохион байгуулан ажлын үр дүнг 2024 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргад танилцуулахыг Мал эмнэлгийн газрын дарга (Г.Одсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



08 дугаар сарын 08 нын өдрийн А.С.Э дугаар  
Аймгийн Засаг даргын 2024 оны  
захирамжийн хавсралт

ХОНИНЫ ЦЭЦЭГ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ЯАРАЛТАЙ  
ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХУВААРЬ

| д/д | Сумын нэр   | Малын тоо      | Вакцин тун     |
|-----|-------------|----------------|----------------|
| 1   | 2           | 3              | 4              |
| 1   | Баяннуур    | 25,000         | 25,000         |
| 2   | Гурванбулаг | 195,000        | 195,000        |
| 3   | Дашинчилэн  | 50,000         | 50,000         |
| 4   | Могод       | 247,000        | 247,000        |
| 5   | Рашаант     | 87,300         | 87,300         |
| 6   | Сайхан      | 37,000         | 37,000         |
|     | <b>Дүн</b>  | <b>641,300</b> | <b>641,300</b> |